



ДАТГАЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН

MSE: XIC

Агуулга

1 Зах зээлийн мэдээ

Ердийн даатгалын салбарын өнөөгийн байдал

6

2 Ард Даатгал компанийн үйл ажиллагаа

Танилцуулга

10

Даатгалын үйл ажиллагаа

12

Онцлох үйл явдал

18

3 Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага

22

4 Хувьцааны арилжааны мэдээ

Хувьцааны арилжааны мэдээ

26

5 Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	27
----------------------------	----

6 Компанийн засаглал

Засаглалын бүтэц үйл ажиллагаа	30
Төлөөлөн удирдах зөвлөл	31

7 Нийгмийн хариуцлага

Нийгмийн хариуцлага	37
---------------------	----


8 Хүний нөөц

Хүний нөөц	42
------------	----

9 2020 оны аудитлагдсан тайлан

Урьдчилсан санхүүгийн тайлан	42
------------------------------	----






Зах зээлийн мэдээ

Ердийн даатгалын салбарын өнөөгийн байдал

Монгол улсад даатгалын салбар үүсч хөгжөөд 87 жил болж байгаа ба Ард Даатгал компани нь байгуулагдаад өдгөө 27 дах жилдээ золгож байна.


2020 онд даатгалын зах зээлд ердийн даатгалын 14, урт хугацааны даатгалын 1, дотоодын давхар даатгалын 1, даатгалын зуучлалын 50 гаруй, даатгалын хохирол үнэлэгч 26 компани тус тус үйл ажиллагаа явуулж байна.




Даатгалын салбарын үзүүлэлт

Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө тайлант хугацаанд 317 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.1 тэрбум төгрөгөөр буюу 12 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь зарим даатгалын компанийн үйл ажиллагаа өргөжиж, хуримтлагдсан ашиг, хураамжийн орлого түүнийг дагаад даатгалын нөөц сан нэмэгдсэнтэй холбоотой юм.


Нийт хураамжийн орлого /тэрбум төгрөг/




Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/



Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/



Нийт нөөц сан /тэрбум төгрөг/




Ердийн даатгалын компаниуд 2020 онд нийт 200 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 тэрбум төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна. Нийт хураамжийн сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 16.1 хувьтай байна. Нийт хураамжаас 8.3 тэрбум төгрөгийн хураамжийн буцаалт хийгдэж, 67 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжийн зардалд зарцуулснаар даатгалын цэвэр хураамжийн орлого 124.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.


Тайлант хугацаанд нийт 59 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 тэрбум төгрөгөөр буюу 8.8 хувиар буурсан ба 187 их наяд төгрөгийн даатгалын үнэлгээ бүхий эрсдэлийг хүлээн авч үүнээс тодорхой хувийг нь давхар даатгалын компанид шилжүүлжээ.

Компаниуд хүлээсэн эрсдэлээ давхар даатгуулах хандлага жил ирэх тусам нэмэгдэж, 67 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг давхар даатгалд шилжүүлсэн байна. Мөн нийтдээ давхар даатгагчаас 5.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг төлүүлсэн байна.


Давхар даатгалын зардал /тэрбум төгрөг/



Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр /тэрбум төгрөг/







Ард Даатгал компанийн үйл ажиллагаа

Компанийн танилцуулга

Ард Даатгал компанийн хувьд Монгол улсын компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж холбогдох хууль, тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагуудыг ханган Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар-2/16) авсан хувьцаат компани юм. Мөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хэрэгжүүлэгч эрх бүхий даатгалын компани юм.

Бидний үйл ажиллагаа нь Иргэний хууль, арилжааны даатгалын холбогдолтой хуулиуд болон СЗХ-ноос гаргасан даатгалын багц дүрмээр зохицуулагддаг ба тус компани нь даатгалын компанийн хувьд зөвхөн даатгалын үйлчилгээ эрхэлдэг төдийгүй Даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 49 дүгээр зүйлд заасны дагуу эрх, үүргээ хүлээн ажилладаг юм. Мөн нээлттэй хувьцаат компани болохын хувьд Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаас гаргагчид холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллаж байгаа билээ.

Ард Даатгал ХК нь 1994 онд Монгол улсын анхны хувийн хэвшлийн даатгалын компани болон байгуулагдаж, даатгалын зах зээлд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Өдгөө Монгол Улсын даатгалын салбарт тэргүүлэгч байр суурь бүхий олон улсад болон дотоодод нэр хүндтэй тогтвортой даатгалын үйлчилгээ үзүүлэгч болсон төдийгүй баялаг бүтээгчдийн найдвартай ар тал болон дэмжиж ажилласаар ирсэн нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулан амжилттай ажиллаж байгааг харуулж байна.



Даатгалын үйл ажиллагаа

Ард Даатгал ХК нь 2020 онд үндэсний хэмжээний үйл ажиллагаа явуулж, Улаанбаатар хот болон орон нутгийн 24 салбар нэгж, төлөөлөгчийн газар, системийн нөлөө бүхий 5 арилжааны банк, олон улсын болон дотоодын 70 гаруй брокер, мэргэжлийн оролцогч зуучлагч, олон тооны банк бус санхүүгийн байгууллага, 100 орчим даатгалын төлөөлөгчдөөрөө дамжуулан улс орон даяар даатгалын үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Компанийн хувьд даатгалын үйлчилгээ өргөжин тэлж борлуулалтын орлого 15.8 тэрбум төгрөгт хүрч өндөр амжилт үзүүлээ.

Ард Даатгал компани нь өнгөрсөн хугацаанд Монгол улсын өнцөг булан бүрт хүрч ажиллаж чадсан бөгөөд 2020 оны байдлаар нийтдээ 190 гаруй мянган даатгуулагчийг даатгалд хамруулаад байгаа төдийгүй үүнээс хоёр мянга гаруй байгууллагатай 15 мянга гаруй гэрээ байгуулж улс орны баялаг бүтээж байгаа бүхий л салбарыг хамруулан даатгалын үйл ажиллагаагаа хүргэн ажиллаж байгаад компанийн хамт олон бахархаж байдаг юм. Тухайлбал:

 Дэд бүтэц, зам тээвэр, иргэний нисэх, агаарын тээвэр

 Барилга угсралт

 Үл хөдлөх хөрөнгө

 Эрчим хүч, уул уурхай, газрын тос

 Хөдөө аж ахуй

 Худалдаа үйлчилгээ

 Хөнгөн ба хүнд үйлдвэрлэл

 Батлан хамгаалах, цэрэг цагдаа, онцгой байдал

 Банк санхүү, даатгал

 Аялал жуулчлал, спорт

 Эрүүл мэнд

 Мэдээлэл технологи, харилцаа холбоо

 Төрийн ба төрийн бус, олон нийтийн байгууллагууд

 Эрдэм шинжилгээ, боловсрол, хууль эрх зүй

 Олон улсын байгууллага, Элчин сайдын яам

гэх мэт бүх салбаруудад хүрч ажиллажээ.

Харилцагчдаас дурьдвал: Энержи ресурс, Оюу Толгой, Эрдэнэт УБҮ, Худалдаа Хөгжлийн банк, Төрийн банк, Хаан банк, Иргэний Нисэхийн Ерөнхий газар, Петровис, Магнай Трейд ХХК, Макс Групп, Онцгой байдлын Ерөнхий газар, Монцемент, М-Си-Эс Холдинг, салбар болон охин компаниуд, Шангрила зэрэг Монгол орны хөгжил дэвшилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа аж ахуйн нэгж, компаниудтай бид хамтран ажилладаг.

Компанийн хувьд харилцагч бүр үнэ цэнэтэй бөгөөд өнгөрсөн жил бид Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас эрэмбэлсэн ТОП-100 аж ахуйн нэгж байгууллагуудын 50 хувиас дээш хэсэг болох аж ахуйн нэгж байгууллагуудад шууд хэлбэрээр, дам хэлбэрээр 80 хувиас дээш хэсэгт нь, мөн 200 гаруй төрийн байгууллагуудад даатгалын үйлчилгээ үзүүлжээ.

Зөвшөөрөгдсөн даатгалын хэлбэрүүдийг авч үзвэл:

- ♥ Эрүүл мэнд гэнэтийн осол
- 🏠 Гадаадад зорчигчид
- 🚒 Барилга угсралт
- 🏠 Хөрөнгө
- 🚗 Авто тээврийн хэрэгсэл
- 🚑 Агаарын хөлөг
- 🏠 Ачаа тээвэр

Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банкны бүх салбар нэгжүүдээр дамжуулан даатгалын олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулж байгаа нь харилцагчийн цагийг хэмнэх, хялбар үйлчилгээ авах боломжоор хангаж байна.


Ард Даатгал компани нь ердийн даатгалын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сайн дурын болон албан журмын төрөл бүхий Санхүүгийн Зохицуулах Хорооноос (СЗХ) тогтоосон сайн дурын даатгалын гэнэтийн осол, амь нас эрүүл мэнд, эд хөрөнгө, хариуцлага, санхүүгийн даатгалын хэлбэрээр 50 гаруй даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байгаа төдийгүй "Жолоочийн даатгалын тухай" хуулийн дагуу жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, сууц өмчлөгчдийн хариуцлагын даатгал, газар тариалангийн даатгал хэрэгжүүлэгч даатгалын ууган компаниудын нэг юм.

- ♥ Эмчилгээний зардлын даатгал
- 🏠 Газар тариалан
- 🚗 Бүх төрлийн хариуцлага
- 🚗 Жолоочийн хариуцлага
- 💰 Санхүү
- 🐄 Малын индексжүүлсэн даатгал
- 🏠 Сууц өмчлөгчийн хариуцлага



Сүүлийн 3 жилийн байдлаар компанийн нийт хураамжийн орлогын бүтцийг авч үзвэл хөрөнгийн даатгал, тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгал, агаарын хөлгийн, гэнэтийн осол эрүүл мэндийн даатгал, хариуцлагын даатгал, барилга угсралтын ажлын даатгалаар хураамжийн орлогын дийлэнх хэсгийг буюу 70-80 гаруй хувийг бүрдүүлсэн байна.

Орон нутгийн нийт борлуулалт /тэрбум төгрөг/




малыг малын индексжүүлсэн даатгалд хамруулж, 220 орчим сая төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлэн, 2020 оны хагас жилийн мал тооллогын дүнг үндэслэн нийт зургаан аймгийн 539 малчин-даатгуулагчид 71,3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна. Даатгагдсан малын сүргийн бүтцийг 5 хошуу малаар авч үзвэл 90 орчим хувийг бог мал эзэлж байна.

Улс орон даяар зохион байгуулагддаг авто тээврийн үзлэг оношлогоотой зэрэгцэн даатгалын борлуулалтаар нийт 432 сум, багт ажиллаж, нийт 19.7 мянга гаруй жолоочийн даатгалыг хийж гүйцэтгэн Жолоочийн даатгалын хуулийн хэрэгжилтийг ханган ажиллажээ.

Цар тахалтай холбоотой иргэдийн хөдөлгөөн, уулзалт, арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарласан, түүнчлэн байгууллага, иргэд, малчдын бодит орлого буурсан зэргээс хамааран даатгалын үйлчилгээний борлуулалт орон нутагт хумигдаж байна.

Ард Даатгал ХК нь МИД-ын төслийн тав дахь жилийн, арван тав дахь борлуулалтын улирлын хугацаанд 21 аймгийн 336 суманд малчдад даатгалын ач холбогдлыг танилцуулан 2,500 орчим малчинтай гэрээ байгуулж, 660 мянга гаруй

МИД-ын борлуулалт /сая төгрөг/



Эрүүл мэндийн даатгал

Ард Даатгал компанийн хувьд Монгол Улсад дотоодод АрдМэнд, олон улсын хэмжээнд ArdMedicare (ArdMed) эрүүл мэндийн даатгалын брэнд бүтээгдэхүүн гарган амжилттай ажиллаж, давхардсан тоогоор 66,5 мянга орчим харилцагчдад эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалтай холбоотой

даатгалын үйлчилгээ үзүүлж, харилцагчдын тоо өсөн нэмэгдлээ. Коронавирусын цар тахлын улмаас иргэд эрүүл мэнддээ илүүтэй анхаарч эхэлсэнтэй холбоотой эрүүл мэндийн даатгалын борлуулалт өсөх хандлагатай байлаа.

Ард түмний эрхэм баялаг эрүүл мэнд

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээгээр 1,392 даатгуулагчид 793 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон ба зөвхөн олон улсын эрүүл мэндийн даатгалаар өнгөрсөн онд 400 орчим сая төгрөгийн нөхөн төлбөрийг төлсөн байна.

ArdMedicare олон улсын эрүүл мэндийн даатгал нь дэлхийн 200 гаруй оронд 330 мянга гаруй гэрээт эмнэлгүүдээр үйлчлүүлэх өргөн сүлжээ бүхий олон улсын MSH-үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллан, хэрэгжүүлдэг бүтээгдэхүүн юм. MSH нь даатгалын компани, даатгуулагч-үйлчлүүлэгч, эмнэлгийн байгууллагыг холбож өгөх гүүр болдог. ArdMedicare Олон улсын эрүүл мэндийн даатгалд Covid-19 вирусийн халдварын эрсдэл хамрагддаг.

Манай харилцагчдын хувьд олон улсын эрүүл мэндийн даатгалын шууд төлбөрийн (direct billing) үйлчилгээг Азийн улсууд болох БНХАУ, Солонгос, Япон, Тайланд, Монгол болон Австрали, Герман, Швед, Швейцарь зэрэг дэлхийн улс орнууд дахь сүлжээ эмнэлгүүдээр үйлчлүүлж авсан байна.

АрдМэнд дотоодын эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг сонголттой, хүртээмжтэй байлгах үүднээс АрдМэнд 360 эрүүл мэндийн даатгалын багц бүтээгдэхүүнийг шинээр зах зээлд гаргалаа. Эрүүл мэндийн даатгалын алба нь мэргэжлийн чадварлаг эмч нар, даатгалын мэргэшсэн мэргэжилтнүүдээр багаа өргөжүүлэн 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Компанийн хувьд салбарын бусад томоохон компаниуд болон Монголиа Ре давхар даагчтай хамтран “Хүнд өвчний даатгалыг” Монгол Улсад анх удаа нэвтрүүлэх ажилд оролцож байна.

Ковид-19 цар тахлын хөл хорионы үед ажиллаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, байгууллагуудын ажиллагсдад зориулж нийгмийн хариуцлагын хүрээнд Ковид-19 өвчний эрсдэлээс хамгаалсан “Ковидын даатгалын” бүтээгдэхүүн шинээр гаргаж олон мянган хүн даатгаад байна. Тус даатгалын бүтээгдэхүүний хувьд байгууллагын ажилтан, албан хаагчид Ковид-19 вирусээр өвчилсөн тохиолдолд эмчилгээний хугацаанд хувь хүний алдагдсан тодорхой хэмжээний орлогыг нөхөн олгох, тасалдуулахгүй байхад чиглэгдсэн даатгалын бүтээгдэхүүн юм.

ТҮҮХЭН ТОВЧООН

1994

- Ард Даатгал ХК үүсгэн байгуулагдав.
- Анхны хувийн даатгалын компани болов.

2000

- Монгол Улсын “ТОП-5” даатгалын компанийн нэг болов.

2004

- Их Британийн “Omni Whittington Group” хөрөнгө оруулагч болов.

2008

- Санхүүгийн Зохицуулах Хорооны “Оны Шилдэг Даатгалын компани”-аар шалгарав.

2010

- “International Quality Era Award” (Switzerland, Geneva) шагнал гардав.
- Агаарын хөлгийн даатгалын үйлчилгээ нэвтрүүлэв.

2011

- Гранд Даатгал ХХК-ийг өөртөө нэгтгэв.
- Оюу толгой төслийн бүтээн байгуулалтад оролцож эхлэв.

2012

- “Гранд экспо”-ийн “Оны шилдэг даатгалын компани” болов.

2013

- МҮХАҮТ-ын шалгаруулалтаар “Оны шилдэг даатгалын компани” болов.

2014

- Монгол Улсын Татварын Ерөнхий Газрын дээд шагнал “Хөх дэвтэр” шагнал гардав.

2015

- Ард Даатгал компанид Ард Санхүүгийн Нэгдэл ХК хөрөнгө оруулагч болов.
- 70 мянган харилцагчдын мэдээллийг агуулсан даатгалын цахим мэдээллийн сантай болов.

2016

- Малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээг үзүүлж эхлэв.
- Давхар даатгалын ТРИТИ гэрээг ХБНГУ-ын давхар даатгагч Ханновер Ре-тэй байгуулав.

2017

- MSH International олон улсын эрүүл мэндийн даатгалыг хэрэгжүүлж эхлэв.
- “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХХК-тай хамтран тариалангийн даатгал хэрэгжүүлж эхлэв.
- Нөхөн төлбөрийг өдөрт нь олгодог болов.
- Монгол Улсын бүхий л аймаг, сумдад хүрч ажилласан баг хамт олныг бүрдүүлж, 40 орчим хувийн өсөлт үзүүлж, харилцагчиддаа 4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож ажиллав.

2018

- IPO гаргаж нээлттэй хувьцаат компани болов.

2019

- Ард Даатгал ХК үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ой тохиов.

2020

- Ард Апп-д даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв
- Ковид-19 цар тахлын хамгаалалт бүхий шинэ даатгалын бүтээгдэхүүн боловсруулж зах зээлд нэвтрүүлэв.
- Харилцагчийн менежментийн (CRM) систем нэвтрүүлэв.
- Хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж 2,069 болов.


Онцлох үйл явдал

- Монгол Улсын уул уурхай, сэргээгдэх эрчим хүчний салбарын даатгалын томоохон тоглогч болов.
- Ковид-19 цар тахлын хөл хорионы үед ажиллаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, байгууллагуудын ажиллагсдад зориулж шинэ даатгалын бүтээгдэхүүн боловсруулж зах зээлд нэвтрүүлэв.
- Хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж 2,069 болов.
- AM Best үнэлгээний компанитай холбоо тогтоож, тэдэнд хандаж компанийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээ хийлгэх ажлыг эхлүүлэх эхний хэлэлцээрийг хийлээ.
- Улаанбаатар хотод УИД-т учирсан галын үүдэлтэй хохирол, мөн гадаад, дотоодын ачааны хохирол зэрэг хэд хэдэн томоохон хохирлуудыг амжилттай нөхөн төлөв.
- Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП 20 индексэд гурван жил дараалан багтав.
- Харилцагчийн менежментийн (CRM) систем нэвтрүүлэв.
- Монгол улсад анх удаа “Хүнд өвчний даатгал”-ын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлээ.
- Ард Санхүүгийн Нэгдэл болон бусад охин компаниудтай хамтран “Хөрөнгө оруулагч үндэстэн-Хөдөө орон нутагт” аянг амжилттай хэрэгжүүлж 21 аймгаар үйл ажиллагаагаа танилцуулав.
- Их Британи Улсын “The Chartered Insurance Institute”-ээс зохион байгуулсан сургалтад хамрагдав.
- Нийт 5 жил, нээлттэй хувьцаат компани болсноос хойш 3 дахь жилдээ дараалан хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилав.
- Ард Лайф ХХК-тай хамтран дэлхийн жишигт хүрсэн тэтгэврийн сангийн тогтолцоог нутагшуулах зорилгоор “Гурвалсан тэтгэврийн хуримтлал”-ын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.
- “АрдКойн” урамшуулалт хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 3 жил осол гаргаагүй осолгүй, манлай жолооч, даатгуулагчиддаа АрдКойн олголоо.

- Мэдээлэл, бүртгэлийн үндсэн систем, харилцагчийн үйлчилгээний систем (call center), харилцагчийн менежментийн систем (CRM) зэргийн уялдааг хангаж ажиллах эхлэлийг тавьж, зайнаас ажиллах арга технологи нэвтрүүлж эхэлсэн ба мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- Цахим даатгалын шийдлийг нэвтрүүлэн, Ард Апп-д даатгалын цэс шинээр нэмэгдэж, апп ашиглагч хэн бүхэн тээврийн хэрэгсэл, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай авах боломжтой боллоо.
- Дэлхийд алдартай телевизийн контент болох Аппрентис Монголиа бизнесийн шоуг Монгол улсад анх удаа Ард Санхүүгийн Нэгдэл зохион байгуулсан бөгөөд тус шоунд АрдМэнд эрүүл мэндийн даатгалаа танилцуулан амжилттай хамтран ажиллалаа.








Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, оновчтой удирдах арга аргачлалыг боловсруулж, компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог шинэчлэн, эрсдэлийг илэрхийлэх индикаторуудыг боловсруулан, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн төдийгүй, эдгээр мэдээллийг ТУЗ-д хүргэн танилцуулж, даатгалын онцлог, харьцаа үзүүлэлтүүд, үйл ажиллагааны хяналтын тогтолцоог ханган ажиллаж байна.

Даатгалын андеррайтингийн үйл ажиллагааг үнэлэх гол үзүүлэлтүүд нь хохирлын болон зардлын харьцаанууд юм. Хохирлын харьцаа, зардлын харьцааны нийлбэрээр хосолсон харьцааг тооцоолох ба уг үзүүлэлт 100 хувиас бага байх нь даатгалын үйл ажиллагаа өгөөжтэй байсанг илэрхийлдэг. 2020 онд компанийн хосолсон харьцаа 93% байна.

Харьцаа үзүүлэлт



LR (хохирлын харьцаа) = Нөхөн төлбөрийн цэвэр зардал / Даатгалын хураамжийн цэвэр орлого

ER (зардлын харьцаа) = Үйл ажиллагааны зардал / Даатгалын хураамжийн цэвэр орлого

CR (хосолсон харьцаа) = LR + ER

Сүүлийн 4 жилийн турш төлбөрийн чадварын зохих түвшинг хангаж ажиллажээ. Тайлант хугацаанд төлбөрийн чадварын үзүүлэлт 132.16 хувь байгаа нь даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ

хугацаанд нь бүрэн биелүүлээд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй, төлбөрийн чадвар нь зохистой түвшинд хангагдсан болохыг илэрхийлж байна.

	Шалгуур	2019 он	2020 он
Төлбөрийн чадварын зохистой харьцаа	$\geq 110\%$	123%	132%

Нөөц сан

Нөөц сан нь даатгалын компани нийт даатгуулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд зориулж байгуулсан мөнгөн хөрөнгө юм. Жилийн эцсийн байдлаар 3.12 тэрбум төгрөгийн нөөц сантай байна. Нөөц сангийн хэмжээ нь жил бүр өссөн байгаа нь компанийн даатгуулагчийн өмнө хүлээх хариуцлагын чадамж улам нэмэгдэж байгааг харуулж байна.

Нөөц сангийн дүн /тэрбум төгрөг/

2020		3.12
2019		3.00
2018		2.29

Давхар даатгал


Ард Даатгал ХК нь 2020 онд 15.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласан ба үүний 4.4 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын компаниудад шилжүүлж эрсдэлээ тараан байршуулсан бөгөөд энэ нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал давхар даатгалын хураамж 92% өссөн байна. Энэ нь барилга угсралтын даатгал, хөрөнгийн даатгалын зарим гэрээг шинээр байгуулж, давхар даатгалд шилжүүлсэнтэй холбоотой үүссэн өсөлт болно.

Давхар даатгалын хэлбэр (сая төгрөг)


Даатгалын хэлбэр	2019 он		2020 он	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	400.7	19.25%	529.3	11.9%
Хөрөнгийн даатгал	1,230.6	59.10%	2,528.2	56.8%
Ачааны даатгал	33.5	1.61%	39.1	0.9%
Барилга угсралтын даатгал	100.8	4.84%	872.1	19.6%
Газар тариалангийн даатгал	18.2	0.87%	40.7	0.9%
Мал амьтдын даатгал	102.4	4.92%	77.8	1.7%
Хариуцлагын даатгал	184.3	8.85%	356.9	8.0%
Санхүүгийн даатгал	11.6	0.56%	8.9	0.2%
Нийт	2,082.1	100%	4,453	100%

Бид давхар даатгалын хувьд ХБНГУ-ын Hannover Re давхар даатгалын компанитай 5 дахь жилдээ хамтран ажиллаж (Whole Account Excess of Loss) трити гэрээгээр нэгж даатгалын зүйлийн хувьд 2 сая долларын хариуцлагын хязгаар бүхий хамгаалалт авч, 2 сая доллараас давсан гэрээ болгоныг тухай бүрт нь (Facultative) давхар даатгалд хамруулан, уг гэрээ нь манай эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэхээс гадна харилцагчдад найдвартай даатгалын хамгаалалт болж өгч байна. Мөн олон улсын эрүүл мэндийн даатгал болон гадаад зорчигчдын даатгалыг Quota Share давхар даатгалд хамруулж дэлхийн бүх оронд үйлчлэх даатгалын цогц хамгаалалтыг бид харилцагчиддаа үзүүлжээ.

Давхар даатгалын төрөл



Давхар даатгалын зах зээл



Ард Даатгал ХК-ийн давхар даатгуулсан эрсдэлийн 40 хувийг Азийн зах зээл, 36 хувийг Европын зах зээл, 9 хувийг ОХУ-н зах зээл мөн 15 хувийг Монгол улсын давхар даатгалын зах зээлд AM Best A++ болон B+ үнэлгээ бүхий давхар даатгагч нарт эрсдэлийг тараан байршуулж ажилласан байна.

Нөхөн төлбөр

2020 онд Ард Даатгал ХК нь нөхөн төлбөрийн үйлчилгээгээр 4,824 даатгалын тохиолдолтой холбоотой 4.7 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж, даатгуулагчдын өмнө хүлээсэн даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүллээ. Тайлант хугацаанд компани давхар даатгалын компаниудтай амжилттай хамтран ажиллаж нийт хохирлын 11.6 хувь буюу 547 сая төгрөгийг давхар даатгагчаар төлүүлж үлдсэн хэсгийг өөрийн нөөц сангаас төлсөн байна. Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн 62 хувь нь хөрөнгийн даатгалд, 38 хувь нь эрүүл мэндийн даатгалаар байна.

Нийт нөхөн төлбөр (сая.төг)


Даатгалын хэлбэр	2019 он		2020 он	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	543.9	12.3%	799.6	16.9%
Хөрөнгийн даатгал	435.4	9.8%	742.3	15.7%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,304.1	29.5%	1,142.1	24.2%
Барилга угсралтын даатгал	3.3	0.1%	15.6	0.3%
Зээлийн даатгал	664.8	15.0%	529.8	11.2%
Жолоочийн хариуцлагын даатгал	1,286.3	29.1%	1,223.2	25.9%
Бусад	185.7	4.2%	266.2	5.6%
Нийт дүн	4,423.4	100%	4,718.7	100.0%

Нийт олгосон нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр задлан харуулбал, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 12.3 хувь буюу 1,607 нэхэмжлэл, тээврийн хэрэгсэл 29.5 хувь буюу 1,238 нэхэмжлэл, жолоочийн даатгал 29.1 хувь буюу 1,651 нэхэмжлэл, үлдсэн хэсэг нь зээлийн даатгал, хөрөнгийн даатгал, хариуцлага бусад хэлбэрийн даатгалд тус тус хамаарахаар байна.

2020 оны хувьд нэгж нэхэмжлэлийн хэмжээ 980 мянган төгрөг болж дунджаар өмнөх оноос 130 мянган төгрөгөөр өссөн байна.

Хувьцааны арилжааны МЭДЭЭ

Ард Даатгал ХК-ийн хувьцааны арилжаа 2020 оны турш 1,643,406 ширхэг хувьцаа, нийт 1.2 тэрбум төгрөгийн үнэлгээтэйгээр арилжаалагдсан бөгөөд оны туршид хувьцааны үнэ 630 төгрөгөөс 800 төгрөгт хүрч хэлбэлзэж оны эцэст 799.96 төгрөгөөр хаагдсан байна.



52 долоо хоногт
Нийт хувьцааны тоо
Нийт арилжааны дүн
Зах зээлийн үнэлгээ


₮630 - ₮800
25,000,000
₮1.2 тэрбум
₮20.0 тэрбум

EPS
BVPS
P/E - Үнэ/Ашиг
P/B - Үнэ/Дансны үнэ


₮83.3
₮521.3
9.6
1.5




Хувьцаа эзэмшигчдийн бүтэц




Ард Санхүүгийн
Нэгдэл




Бусад



Ард Лайф ХХК



Би Ди Сек ҮЦК ХК



Энержи Интернэйшнл
Капитал ХХК







Компанийн засаглал

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа

Бид 2018 онд IPO хийж Монголын Хөрөнгийн Биржийн хувьцааны 1-р ангилалд багтан анхдагч зах зээлийн захиалгаар 1,359 хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат компани болсон ба 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар энэ тоо 2,069 болж өсөөд байна.

Компани нь үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч ТОП 20 индексэд нээлттэй хувьцаат компани болсноосоо хойш 3 жил дараалан багтаж ирлээ.

Ард Даатгал ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл удирддаг.

Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хувь хүн буюу Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилно.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийг өөрчлөн байгуулах, ТУЗ-ийн гишүүнийг сонгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах, компанийн хэлбэрийг өөрчлөх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг байна.

Ард Даатгал ХК нь Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлаа 2020 оны 4 сарын 29-ны өдөр Ковид-19 цар тахлаас урьдчилсан сэргийлэх, бүх нийтийн

бэлэн байдал зарласантай холбогдон анх удаа цахимаар амжилттай зохион байгууллаа. Хуралд нийт 22,020,448 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид оролцож, 88.08 хувийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг хэлэлцэн батлав.

1. Ард Даатгал ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг 99.67 хувийн саналаар батлав.

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаар шийдвэр гаргаж ажилладаг.

2019 оны 4 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгосон бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба

тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 6 ердийн, 3 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. ТУЗ-ийн даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн гүйцэтгэх захирал Чулууны Ганхуяг ажиллаж байна.

ТУЗ-ийн хурлаар жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, улирал тутам хуралдан төлөвлөгөөний биелэлтийг тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлэг өгч ажиллаж байна.

ТУЗ-ийн дарга



Чулууны **Ганхуяг**

Ард Санхүүгийн Нэгдэл ХК
Гүйцэтгэх захирал, , Үүсгэн байгуулагч

ТУЗ-ийн Ердийн гишүүд



Одончимэд **Одбаяр**

Ард Санхүүгийн Нэгдэл ХК,
ТУЗ-ийн гишүүн



Галбадрах **Цогбадрах**

Ард Даатгал ХК
Гүйцэтгэх захирал



Батбилэг **Золбоо**

Ард Санхүүгийн Нэгдэл ХК
Санхүү эрхэлсэн захирал



Чулуун **Ганзориг**

Номадик Офф-Рөүд ХХК
Гүйцэтгэх захирал, Үүсгэн байгуулагч



Сүхдорж **Оргил**

Мост ПСП ХХК
Гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн хараат бус гишүүд



Зоригт **Ариун**

Америк сургууль
Зөвлөх



Баатарзоригт **Болорчимэг**

Өрөг.мн
Үүсгэн байгуулагч



Ичинхорлоо **Сэр-Од**

Монголын Бизнесийн Зөвлөл
Захирал

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2020 онд нийт хоёр удаа эчнээгээр, дөрвөн удаа ээлжит хурал зохион байгуулсан бөгөөд цаг үеийн тулгамдсан чухал асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэж ажиллалаа.

Огноо	Ирц	Шийдвэрлэсэн асуудлууд
2020.2.17 /эчнээ/	100%	1. ТУЗ-ийн эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах тухай 2. Ард Даатгал ХК-ийн 2019 оны цэвэр ашгаас 50 хувь буюу 850 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилах
2020.3.16 /эчнээ/	100%	1. ТУЗ-ийн эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах тухай 2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар зарлан хуралдуулах тухай
2020.4.14 /ээлжит/	89%	1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар О.Одбаярыг сонгох 2. Гүйцэтгэх захирлын 2019 оны гүйцэтгэлийн үр дүнг батлах тухай 3. Компанийн 2019 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах тухай 4. Гүйцэтгэх захирлын 2020 оны төлөвлөгөөг батлах тухай
2020.7.20 /ээлжит/	89%	1. Аудитын хорооны дүрмийг шинэчлэн батлах тухай 2. Мөнгө угаах, терроризмтой тэмцэх хөтөлбөр батлах тухай 3. ТУЗ-ийн гишүүдийн цалинг батлах тухай 4. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам шинэчлэн батлах тухай
2020.10.29 /ээлжит/	89%	1. Үл хөдлөх хөрөнгө худалдан авах тухай 2. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Г. Баярбатыг томилохыг зөвшөөрч, зохих зөвшөөрлийг СЗХ-ноос авах тухай 3. Грант Торнтон аудит компаниар хөндлөнгийн аудит хийлгэх тухай 4. ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны нарийн бичгээр ажиллаж байсан А.Батболдыг ажлаас чөлөөлж, Т.Батцэнгэлийг тус хорооны нарийн бичгээр томилох;
2020.12.10 /ээлжит/	89%	1. 2021 оны Давхар даатгалын стратегийн төлөвлөгөө батлах тухай 2. 2021 оны ТУЗ-ийн хурлын тов батлах тухай 3. 2021 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах тухай 4. 2021 оны Төсөв, төлөвлөгөө батлах тухай 5. 2021 оны ТУЗ-ийн төсөв батлах тухай

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Ард Даатгал ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороог тус тус зохион байгуулан ажилладаг.

Аудитын хороо

Аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, аудитын байгууллагыг сонгох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Бүрэлдэхүүн: Хорооны дарга З.Ариун
Хорооны гишүүд: О.Одбаяр, И.Сэр-Од

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тэдгээрийн цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн

талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Бүрэлдэхүүн: Хорооны дарга Ч.Ганзориг
Хорооны гишүүд: Б.Болорчимэг, З.Ариун

Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо

Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо нь компанийн стратеги төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-д танилцуулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн тайлан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн стратеги төлөвлөлтөд нийцсэн эсэхэд хяналт тавих, дүгнэлт гаргах, компанийн хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Бүрэлдэхүүн: Хорооны дарга Б.Золбоо
Хорооны гишүүд: Г.Цогбадрах, И.Сэр-Од, С.Оргил, Б.Болорчимэг





Нийгмийн хариуцлага


Ард Даатгал ХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд, үйл ажиллагаагаа нээлттэй ил тод явуулан, харилцагч даатгуулагч, хамтрагч түнш байгууллага, олон нийт, ажиллагсдынхаа өмнө бизнесийн ёс зүй, хэм хэмжээг зарчим болгон улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар нийт хамт олноороо чармайн ажиллаж байна. Бид 2020 онд :

- Хамт олны санаачлагаар Цус сэлбэлт судлалын үндэсний төвд ажилчид цусаа хандивлалаа.
- Дэлхий дахинд тархаад байгаа цар тахлын үед халдвараас сэргийлэх зорилгоор Улсын Онцгой Комиссоос хөл хорио тогтоон, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал зарласан билээ. Тус шийдвэртэй холбогдуулан нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг хийж ажиллалаа. Үүнд :
 - Салбаруудын ажиллах цагийн хуваарийг тодорхой хугацаанд багасган, харилцагчдыг аль болох салбаруудад ирүүлэхгүйгээр даатгалын үйлчилгээг хүргэх ажлуудыг шат дараатайгаар зохион байгуулан ажилласан.
 - Салбаруудаар үйлчлүүлж буй харилцагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс байнгын ариутгал халдваргүйжилт хийн, халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм барьж ажиллаж байна.
 - Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу бага насны хүүхэдтэй ажилчдыг тодорхой хугацаанд зайнаас ажиллах боломжоор ханган, цагийн хуваарийг уян хатан нөхцлөөр зохицуулалт хийн ажилласан.
 - Мэдээлэл технологи, цахим хэрэглээ өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа өнөө үед бүх төрлийн даатгалыг харилцагчдад хурдан шуурхай хүргэх зорилгоор Ард Апп-д даатгалын үйлчилгээг нэвтрүүлээ.
- Харилцагчдын цаг завьг хэмнэх, гэрээ хүргэлтийг хялбар болгох ажлын хүрээнд утсаар даатгал хийн, даатгуулагчийн байгаа газарт нь шуудангаар хүргэж өгөх үйлчилгээг үзүүлж байна.
- Циркийн жүжигчин, экстрим артист М.Мягмарсайханыг дэмжин хамтран ажилласан. Тэрээр эх орондоо анх удаа “Тэнгэрийн алхаа”-г Өвөрхангай аймгийн Улаан цутгалан хүрхрэн дээгүүр 28 метрийн өндөр 57 метр тросс байршуулж алхсан. 2020 онд Архангай аймгийн Чулуутын хавцал дээгүүр мөн тросс байршуулж алхсан байна.
- Ард Даатгал компанийн ажиллагсад өөрсдийн санаачлагаар “Зүрх мартаггүй” төсөлд нэг өдрийн цалингаа хандивлаж бяцхан зүрхэнд амьдрал бэлэглэлээ.
- Ковид-19 цар тахлын үед, түүнчлэн хөл хорионы үед ажиллаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, байгууллагуудын ажиллагсдад зориулж нийгмийн хариуцлагын хүрээнд Ковид-19 өвчний эрсдэлээс хамгаалсан “Ковидын даатгалын” бүтээгдэхүүн шинээр гаргаж олон мянган хүн даатгаад байна. Тус даатгалын бүтээгдэхүүний хувьд байгууллагын ажилтан, албан хаагчид Ковид-19 вирусээр өвчилсөн тохиолдолд эмчилгээний хугацаанд алдагдсан тодорхой хэмжээний орлогыг нь нөхөн олгох, тасалдуулахгүй байхад чиглэгдсэн даатгалын бүтээгдэхүүн юм.

- Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосон үеүдэд харилцагч, даатгуулагчдын эрүүл мэндийг хамгаалах, даатгалын үйлчилгээг илүү ойр болгох үүднээс нөхөн төлбөрийн материалыг цахимаар хүлээн авч шийдвэрлэдэг болов.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд Улаанбаатар хотоос гадна орон нутгийн замд замын хөдөлгөөний ослоос сэргийлэх самбар байршуулах, сургууль, цэцэрлэгийн орчинд анхааруулах тэмдэг байршуулах, жолооч нарт ослоос сэргийлэх санамж тараах, нийтийн гудамж, талбай цэвэрлэх, ариутгалын бодис, хамгаалах хэрэгсэл хандивлах зэрэг ажлуудыг шат дараатай зохион байгууллаа.
- Монгол Улсын бүх аймгуудад, мэдээлэл бага хүрдэг алслагдсан орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, тэтгэврийн даатгал танилцуулах ажлын хүрээнд сургалт хэлэлцүүлэг зохион байгуулан, ажиллахын зэрэгцээ хөрөнгө оруулагч үндэстэн-орон даяар сурталчилгааны аян, Монголын хамгийн анхны хөрөнгө оруулалтын сан Үндэсний хувьчлалын санд тухайн орон нутгийн иргэдийг нэгдэхэд нь дэмжин ажиллав.





A large, light gray, stylized number 8 serves as the background for the text. It has a thick, rounded stroke and a central white oval cutout.

Хүний нөөц

Хүний нөөц

Ард Даатгал компани нь 100 орчим үндсэн ажилтантай, Улаанбаатар хотын бүх дүүрэг, Эрдэнэт, Дархан хотууд болон бүх аймаг орон нутагт нийтдээ 24 салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан борлуулалтын сүлжээг хэдийнээ бий болгосон төдийгүй 100 гаруй даатгалын борлуулалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий төлөөлөгчидтэй хамтран ажиллаж байна.

Нийт ажиллагсдын 80 гаруй хувийг санхүү, эдийн засаг, даатгал, хууль эрх зүй, бизнесийн удирдлага, менежмент болон авто инженер, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд эзэлж байгаа ба 30 гаруй хувь нь магистрын зэрэг хамгаалжээ.

Компани Монгол Улсын даатгалын зах зээлд 5-20 жил ажиллаж байгаа даатгалын чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэн, олон жилийн турш эгнээндээ нэгтгэн ажилласны үр дүнд нийт ажиллагсдын 60

гаруй хувь нь таваас дээш жил ажиллаж туршлага хуримтлуулсан, зах зээл дэх хамгийн туршлагатай ажилтнуудтай компани болсон байна.

Манай компанид Их Британи, БНХАУ, АНУ, ХБНГУ, Хонконг, Сингапур, ОХУ, Япон, Энэтхэг, Малайз, Вьетнам зэрэг улсуудад даатгалын сургалтад хамрагдсан, Лондонгийн даатгалын институтээс олгосон олон улсын даатгалын зах зээлд ажиллах эрх бүхий чадварлаг, мэдлэг, туршлага арвин мэргэжилтнүүд ажилладаг.

Бид ажиллагсдаа давтан сургах, багаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд анхаардаг бөгөөд гадаадын мэргэшлийн сургалтуудад хамрууллаа. Тухайлбал, олон улсын даатгалын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, Их Британи Улсын Лондонд төвтэй нэр хүндтэй институт болох CII(The Chartered Insurance Insurance)-д хоёр шатны сургалтуудад давхар даатгалын албаны мэргэжилтнүүд хамрагдаж

амжилттай дүүргэв. Мөн Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс хамтран ХБНГУ-д зохион байгуулсан Олон улсын түвшний менежер бэлтгэх сургалт, хөтөлбөрт, Японы “General insurance Institute of Japan” зохион байгуулагдсан Ердийн даатгалын цахим сургалтад удирдлагын багийн гишүүд амжилттай хамрагдлаа.

Улс даяар 2020 онд хөл хорио тогтоосон хязгаарлагдмал нөхцөл байдалтай байсан хэдий боловч менежерүүдийн мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хөгжүүлэх ажлыг хойшлуулахгүйгээр МҮХАҮТ-аас зохион байгуулсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрх зүйн орчин, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах зааварчилгаа” сэдэвт цахим сургалтанд даатгалын менежерүүдийг оролцууллаа.

Олон улсад зохион байгуулагддаг 2020 оны Сингапурын даатгал, давхар даатгалын конференс(SIRC-2020)-д онлайнаар оролцож давхар даатгалын болон брокерын компаниудтай харилцаа тогтоон, гадаад харилцааг идэвхжүүлэн, өргөжүүллээ.

Ажиллагсдын нийгмийн асуудлыг анхаарах хүрээнд ирээдүйн хуримтлалыг бий болгох үүднээс тэтгэврийн хуримтлалын санд хамруулан, мөн хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилладаг.

НОГДОЛ АШГИЙН ТАЙЛАН

Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 2 сарын 17-ны өдрийн №1/20-2 тоот тогтоолын дагуу компанийн 2019 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 34 төгрөг буюу цэвэр ашгийн 50 хувь болох нийт 850 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Ногдол ашгийг 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр буюу 2020 оны 4 сарын 9-ний байдлаар Ард Даатгал ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олголоо.

Компанийн зарласан ногдол ашгийг 2020 оны 5 сарын 20-ны өдөр “Үнэт Цаас Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-тай байгуулсан ногдол ашиг зуучлуулан тараалгах гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүллээ.





Аудитлагдсан санхүүгийн тайлан



"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудиторын дүгнэлт

Далай тэвэр 9 давхар, ЮНЕСКО
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 fl, UNESCO street,
Sukhbaatar District-1, Ulaanbaatar
14230, Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

"Ард даатгал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид "Ард даатгал" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь "хураангуй санхүүгийн тайлан" гэж) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Сангийн сайдын 2020 оны 132 тоот тушаалаар батлагдсан "Даатгалын компаниудад мөрдөгдөх Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга"-д шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул "Ард даатгал" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй болно.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн. Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудал нь Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн тооцоололтой холбоотой асуудал байсан бөгөөд бид энэ асуудлаар дүгнэлтээ хязгаарлаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох заавар, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын "Аудитын тухай" хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.



Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,176,594	422,095
Даатгалын авлага	2,144,557	755,868
Бусад санхүүгийн хөрөнгө	693,824	1,129,819
Бусад санхүүгийн бус хөрөнгө	921,909	611,568
Хөрөнгө оруулалт	18,009,392	15,179,497
Даатгалын хөрөнгө	3,401,296	1,514,608
Үндсэн хөрөнгө (цэвэр)	2,428,893	1,036,618
Биет бус хөрөнгө (цэвэр)	-	173,590
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Нийт хөрөнгө	28,776,465	20,823,663
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Даатгалын өглөг	3,142,938	699,938
Бусад санхүүгийн өр төлбөр	1,151,113	109,278
Бусад санхүүгийн бус өр төлбөр	372,405	329,299
Орлогд тооцоогүй хураамжийн нөөц	7,690,100	4,875,238
Нөхөн төлбөрийн нөөц сан	3,120,927	3,004,901
Нийт өр төлбөр	15,477,483	9,018,654
Эздийн өмч		
Эзэмшигчдийн өмч	5,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал	3,280,854	3,280,854
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	5,018,128	3,524,155
Эздийн өмчийн дүн	13,298,982	11,805,009
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	28,776,465	20,823,663

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Даатгалын үйл ажиллагаа		
Даатгалын хураамжийн нийт орлого	15,713,525	11,409,425
Даатгалын хураамжийн буцаалт	201,560	431,198
Давхар даатгалын хураамжийн зардал	4,386,090	2,082,097
Даатгалын хураамжийн цэвэр орлого	11,125,875	8,896,130
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	2,814,862	(1,302,939)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	1,382,690	(575,265)
Орлогод тооцсон хураамж	9,693,703	9,623,804
Нийт нөхөн төлбөрийн зардал	4,718,694	4,423,371
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	547,323	450,787
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	503,943	123,843
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	3,667,428	3,848,741
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	306,019	382,445
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	(317,166)	(125,659)
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	(189,993)	330,854
Зардалд тооцсон нөхөн төлбөр	3,466,288	4,436,381
Даатгалын гэрээний зардал	1,810,430	1,953,933
Давхар даатгалын шимтгэлийн орлого	131,276	180,383
Хөрөнгө оруулалтын орлого ба олз	2,515,906	2,410,782
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)	7,064,167	5,824,655

Хүү, эрхийн шимтгэлийн орлого	45,009	36,259
Бусад орлого	197,754	213,906
Ерөнхий ба удирдлагын зардал	1,809,879	1,771,322
Борлуулалт, маркетингийн зардал	2,451,983	2,251,051
Санхүүгийн зардал	22,500	3,038
Бусад зардал	618,014	42,716
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(30,853)	2,938
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	837	(3,066)
Бусад ашиг (алдагдал)	(4,689,629)	(3,823,966)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,374,538	2,000,689
Орлогын татварын зардал	226,737	281,940
Татварын дараах ашиг (алдагдал)	2,147,801	1,718,749
Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
Орлогын нийт дүн	2,147,801	1,718,749
Нэгж хувьцаанд ногдох ашиг	85.91	68.75

Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	19,585,334	13,128,651
Даатгалын хураамжийн орлого	14,109,947	11,284,554
Давхар даатгалын нөхөн төлбөр	98,428	-
Буруутай этгээдийн төлсөн нөхөн төлбөр	-	124,002
Бусад мөнгөн орлого	5,376,959	1,720,095
Мөнгөн зарлагын дүн	18,431,913	14,022,737
Ажиллагчдад төлсөн	1,356,397	1,351,071
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	188,991	386,351
Бараа материал худалдан авахад төлсөн	142,150	100,229
Ашиглалтын зардалд төлсөн	6,489	9,766
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	1,442,866	1,694,525
Нөхөн төлбөрт төлсөн		
Үүнээс: Сайн дурын даатгалын	3,370,207	3,357,224
Албан журмын даатгалын	1,180,243	1,281,305
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	1,236,143	1,003,604
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	761,647	722,446
Даатгалын хохирол үнэлэгчдэд төлсөн төлбөр	13,422	8,184
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	61,535	54,959
Татварын байгууллагад төлсөн	710,297	489,619
Даатгалын төлбөрт төлсөн	18,876	64,380
Бусад мөнгөн зарлага	7,942,650	3,499,074
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,153,421	(894,086)

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	8,086,298	4,858,890
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,700	131,884
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	6,808,378	4,011,455
Хүлээн авсан хүүний орлого	1,236,348	708,738
Хүлээн авсан ногдол ашиг	33,872	6,813
Мөнгөн зарлагын дүн	8,339,501	3,609,867
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,035	81,998
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,700	8,250
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	8,315,766	3,519,619
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(253,203)	1,249,023
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Мөнгөн зарлагын дүн	151,490	286,183
Төлсөн ногдол ашиг	151,490	286,183
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(151,490)	(286,183)
Валютын ханшийн зөрүү	5,771	37,513
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	754,499	106,267
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	422,095	315,828
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,176,594	422,095

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	5,000,000	3,280,854	2,438,556	10,719,410
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(1,448)	(1,448)
Залруулсан үлдэгдэл	5,000,000	3,280,854	2,437,107	10,717,962
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1,718,749	1,718,749
Зарласан ногдол ашиг			(631,702)	(631,702)
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	5,000,000	3,280,854	3,524,155	11,805,009
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			196,172	196,172
Залруулсан үлдэгдэл	5,000,000	3,280,854	3,720,327	12,001,181
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			2,147,801	2,147,801
Зарласан ногдол ашиг			(850,000)	(850,000)
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	5,000,000	3,280,854	5,018,128	13,298,982
Даатгалын гэрээний зардал			1,810,430	1,953,933
Давхар даатгалын шимтгэлийн орлого			131,276	180,383
Хөрөнгө оруулалтын орлого ба олз			2,515,906	2,410,782
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)			7,064,167	5,824,655

2020

Хүчтэй. Хамтдаа.